



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ХАНГИ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/12

Хатанбулаг сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/142 дугаар тушаалын "Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.4, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай 12 дугаар зүйл, Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтын 2.2 дахь хэсэг, Ханги дахь гаалийн газрын нийт албан хаагчдын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Ханги дахь гаалийн газрын нийт албан хаагчдын санал хураалтаар "Ёс зүйн дэд хороо"-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хороон дарга:  
Д.Учралт

Захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч

Дэд хорооны гишүүн:  
Ш.Нанжид

Хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ч.Цэцэгмаа

Эрүүл ахуй, стандартын хяналт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч

А.Бат-Өлзий

Зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч

Нарийн бичгийн дарга:  
С.Өнөболд

Захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын байцаагч

2. Дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан ажиллахыг дэд хорооны дарга захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын байцаагч (Д.Учралт)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЦОЛБАЯР



2120001050

  
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ОРХОН АЙМАГ  
ОРХОН АЙМАГ ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/14

Баян-Өндөр сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1,13.2 дахь хэсэг, Улсын их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.4, 4.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын саналыг үндэслэн Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ёс зүйн дэд хорооны дарга:

Б.Тунгалагтамир

Захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч

Гишүүд:

Г.Болормаа

Хяналт, бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч

Б.Батмэнд

Хяналт, бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч

Х.Соёлмаа

Улсын орлогын бараа, тооцоот хуудас, аж ахуй хариуцсан нярав

Нарийн бичгийн дарга:

М.Батцэцэг

Хяналт, бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг хангуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, Гаалийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо болон удирдлагад үйл ажиллагаагаа тайлагнаж ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Б. Тунгалагтамир)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч (А.Сувдмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



В. МАЙДАРМАА





ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОРНОГОВЬ АЙМАГ  
САЙНШАНД ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_ өдөр

Дугаар А/\_\_\_

Сайншанд сум

**Ёс зүйн дэд хороо байгуулах тухай**

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалт, Гаалийн тухай хуулийн 269<sup>1</sup> дүгээр зүйлийн 269<sup>1</sup>.1.8 дахь заалт, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоол “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ийн 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалт, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус гаалийн газрын Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Нарийн бичгийн дарга:

- Б.Мөнхтуяа (Зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч)

Гишүүд:

- Г.Анхбаатар (Бор-Өндөр салбарын эрхлэгч)
- Б.Бат-Эрдэнэ (Айраг салбарын эрхлэгч)
- Д.Батбаатар (Гаалийн улсын ахлах байцаагч)
- О.Оюунмаа (Гаалийн улсын байцаагч)

2.Гаалийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд холбогдох мэдээлэл хүргүүлэх, тушаалийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч (Н.Ууганчимэг)-т даалгасугай

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Н.БАТЦЭНГЭЛ

Пүрэвтогоочийн Оргилбаатар  
(Хяналт, шалгалтын албаны хяналт хариуцсан  
гаалийн улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: Сосорбурамын Мөнхцэцэг  
(Захиргааны албаны захиргаа, хүний нөөц  
хариуцсан гаалийн улсын байцаагч)

2. Ёс зүйн дэд хороонд үүрэг болгох нь:

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах,

2.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх чиг үүргийг хэрэгжүүлэх,

2.3. Дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулах,

2.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж, Гаалийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд хүргүүлэх, ажлын уялдаа холбоотой ажиллах.

3. Дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийн урамшуулал, чадавхжуулахтай холбогдох зардлыг жил бүр байгууллагын төсөвт тусган батлуулж, санхүүжүүлэхийг Санхүү, аж ахуйн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Удвалмядаг)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ЦЭЭНРЭГЗЭН





ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ  
ЗАМЫН-ҮҮД ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/18

Замын-Үүд сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 269<sup>1</sup> дүгээр зүйлийн 269<sup>1</sup>1.8 дахь заалт, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.5, 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.4, 2.7 дахь хэсэг, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.2.7, 4 дүгээр зүйлийн 4.3.4 дэх заалт, Замын-Үүд дэх гаалийн газрын албан хаагчдын санал, асуулгын дүн, тус газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Замын-Үүд дэх гаалийн газрын дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-ны бүрэлдэхүүнийг 7 гишүүнтэйгээр 5 жилийн хугацаатай байгуулсугай. Үүнд:

Дарга:	НямзайнТөрсайхан (Эрсдэлийн удирдлагын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Ганбаатарын Удвалмядаг (Санхүү, аж ахуйн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) Сэрээтэрийн Баярмаа (Хяналт, шалгалтын албаны хяналт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч) Даваасүрэнгийн Амартүвшин (Зөрчилтэй тэмцэх албаны зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч) Сүхбаатарын Солонго (Хорио цээрийн албаны Мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч)

44 24 01 073



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОРНОД АЙМАГ  
ДОРНОД АЙМАГ ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/119

Хэрлэн сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, 10.5 дахь хэсэг, 13 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, Гаалийн тухай хуулийн 274 дүгээр зүйлийн 274.2.5 дахь заалт, Улсын их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2, 3, 4, 5 дугаар зүйл, Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 534 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”, 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.3, 3.2.5, 3.2.7 дахь заалт, 2024 оны “Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” А/123 дугаар тушаалын 6 дугаар хавсралт, 2019 оны А/142 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Дэд хорооны дарга - Л.Хишигдорж (Хяналт бүрдүүлэлт, хорио цээрийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичиг - Б.Тэгшжаргал (Гаалийн улсын байцаагч)

Гишүүд - С.Төрцэцэг (Салбар лабораторийн эрхлэгч бөгөөд шинжээч гаалийн улсын ахлах байцаагч)

П.Одсүрэн (Хяналт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч)

Э.Энхзул (Гаалийн улсын байцаагч)

2. Газрын хэмжээнд албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох тайлан мэдээг гарган удирдлагыг мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг ёс зүйн дэд хорооны гишүүд, нарийн бичигт даалгасугай.

070422232

3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга (Л.Хишигдорж) - д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ГЭРЭЛТ-ОД







ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДАРХАН-УУЛ АЙМАГ  
ДАРХАН-УУЛ АЙМАГ ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/22

Дархан сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь хэсэг, Гаалийн тухай хуулийн 274 дүгээр зүйлийн 274.2.5 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Улсын их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.4, 4.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус гаалийн газарт ажиллах Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.


Ёс зүйн дэд хорооны дарга: Гаалийн хяналт, бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч С.Өнөрсайхан

Гишүүд: Мал эмнэлгийн хяналтын хариуцсан гаалийн улсын байцаагч Ч.Мөнхбат  
Нарийн бичиг: Зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан гаалийн улсын байцаагч Я.Оюундэлгэр

2.Ёс зүйн дэд хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлж, Гаалийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд ажлаа тайлагнаж ажиллахыг үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөц хариуцан ажиллаж байгаа гаалийн улсын байцаагч (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ГҮЙЦЭТ ГЭГЧ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТ ГЭГЧ Ч.ЦЭНДСҮРЭН



451811085



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМ  
ГАСУУНСУХАЙТ ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

20 24 оны 07 сарын 31 өдөр

Дугаар A/22

Ханбогд сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, 10.5 дахь хэсэг, 13 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, Гаалийн тухай хуулийн 274 дүгээр зүйлийн 274.2.5 дахь заалт, Улсын их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2, 3, 4, 5 дугаар зүйл, Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 534 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм", 2022 оны A/226 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.3, 3.2.5, 3.2.7 дахь заалт, 2024 оны "Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" A/123 дугаар тушаалын 6 дугаар хавсралт, 2019 оны A/142 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Дэд хорооны дарга:

Г.Отгонтуяа (Бүрдүүлэлтийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичиг:

Ц.Энх-Амгалан (Зөрчилтэй тэмцэх албаны Зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч)

Гишүүд:

З.Бямбадорж (Хяналт шалгалт, хорио цээрийн албаны хяналт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч)

Ж.Хаш-Эрдэнэ (Хяналт шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч)

Б.Гэрэлмаа (Захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын байцаагч)

2. Газрын хэмжээнд албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох тайлан мэдээ гарган удирдлагыг мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг ёс зүйн дэд хорооны гишүүд, нарийн бичигт даалгасугай.

3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга (Г.Отгонтуяа) - д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ГАНБАЯР  
КЮА0068  
4618123013 9133498





ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
СҮХБААТАР АЙМГИЙН ЭРДЭНЭЦАГААН СҮМ  
СҮХБААТАР АЙМАГ БИЧИГТ  
ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 1105

Эрдэнэцагаан сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 269<sup>1</sup> дүгээр зүйлийн 269<sup>1</sup>.8 дахь заалт, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.5, 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.4, 2.7 дахь хэсэг, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.7, 4 дүгээр зүйлийн 4.3.4 дэх заалт, Бичигт дэх гаалийн газрын албан хаагчдын санал, асуулгын дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Бичигт дэх гаалийн газрын дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-ны бүрэлдэхүүнийг 3 гишүүнтэйгээр 5 жилийн хугацаатай байгуулсугай.

Дарга: Ш.Жадамбаа /Зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан  
гаалийн улсын байцаагч/

Гишүүд: Г.Мөнх-Эрдэнэ /Хяналт, бүрдүүлэлт хариуцсан  
гаалийн улсын байцаагч/

Нарийн бичгийн дарга: Ш.Энхтунгалаг / Хяналт, бүрдүүлэлт хариуцсан  
гаалийн улсын байцаагч/

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулаж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга гаалийн улсын байцаагч (Ш.Жадамбаа)-д үүрэг болгосугай.

3. Дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийн урамшуулал, чадавхжуулахтай холбогдох зардлыг жил бүр байгууллагын төсөвт тусган батлуулж, санхүүжүүлэхийг Нягтлан бодогч гаалийн улсын байцаагч (А.Алтан-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  Н.АМАРБААТАР



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ  
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/06

Өлгий сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.2, 4.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус гаалийн газрын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд хорооны дарга: Гаалийн хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн албаны дарга

Гишүүд: Салбарын эрхлэгч

Ахлах нягтлан бодогч гаалийн улсын ахлах байцаагч

Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэгч гаалийн улсын ахлах байцаагч

Нарийн бичгийн дарга: Захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг гаалийн хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн албаны дарга (Ж.Уламбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Б.ХУЯГБААТАР





ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ЗАВХАН АЙМГИЙН ТЭС СУМ  
ЗАВХАН АЙМАГ АРЦСУУРЬ ДАХЬ ГААЛИЙН ХОРООНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 07 сарын 30 одор

Дугаар А/05

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 269<sup>1</sup> дүгээр зүйлийн 269<sup>1</sup>.8 дахь заалт, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.5, 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.4, 2.7 дахь хэсэг, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.7, 4 дүгээр зүйлийн 4.3.4 дэх заалт, Арцсуурь дахь гаалийн хорооны албан хаагчдын санал, асуулгын дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Арцсуурь дахь гаалийн хорооны дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-ны бүрэлдэхүүнийг 3 гишүүнтэйгээр 5 жилийн хугацаатай байгуулсугай.

Дарга:	Д.Энхбат / Хяналт, бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч/
Гишүүд:	Э.Цэрэнханд /Хяналт, бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч/
Нарийн бичгийн дарга:	П.Пэрэнлэй / Мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч/

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга гаалийн улсын ахлах байцаагч (Д.Энхбат)-д үүрэг болгосугай.

ХОРООНЫ ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ӨРДОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

М. СЭРСЭНЖАВ



000000481



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМ  
ШИВЭЭХҮРЭН ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/11

Гурвантэс сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4 дэх заалт, Гаалийн ерөнхий газрын харьяа Шивээхүрэн дэх гаалийн газрын хамт олны санал, асуулгын дүн, Ёс зүйн дэд хорооны 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэл, Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Шивээхүрэн дэх гаалийн газрын "Ёс зүйн дэд хороо"-ны бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэйгээр 5 жилийн хугацаатайгаар баталсугай.

Дарга: Дашдорж Батцоож	Зөрчилтэй тэмцэх аюулгүй байдал хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч
Гишүүд: Жамъян Түвшинтөгс	Гаалийн хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч
Оюунбат Урандарь	Байгаль орчны хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч
Пүрэвдоо Байгалмаа	Бага эмч
Нарийн бичиг: Цэрмаа Бадамцэцэг	Захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын байцаагч

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.

3. Ёс зүйн дэд хороонд шаардлагатай санхүүжилтийг тухай бүр шийдвэрлэж, байгууллагын төсөвт тусгуулахыг Санхүү, аж ахуйн албаны ахлах нягтлан бодогч гаалийн улсын ахлах байцаагч (Б.Амартүвшин)-д даалгасугай.

4. Холбогдох тайлан, мэдээг Гаалийн ерөнхий газрын дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-нд хүргүүлж, тайлагнахыг Нарийн бичиг (Ц.Бадамцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.ӨНӨРБУЯН





ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/212

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4 дэх заалт, Гаалийн ерөнхий газар, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодын санал, асуулгын дүн, Ёс зүйн дэд хорооны гишүүдийн 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-ны бүрэлдэхүүнийг 7 гишүүнтэйгээр 5 жилийн хугацаатайгаар баталсугай.

Дарга: Даваагийн Цэндсүрэн	Эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албаны үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд: Эрдэнэхүүгийн Лхагвасүрэн	Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга
Батаагийн Болормаа	Хяналт бүрдүүлэлтийн газрын гаалийн улсын ахлах байцаагч
Өвгөний Тэгшээ	Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч
Эрдэнэбаярын Жамъянсүрэн	Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын Хяналт, шалгалтын албаны эрэлч нохой хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч
Түвшинтөрийн Энхцэцэг	Замын-Үүд дэх гаалийн газрын Захиргааны албаны захиргаа, хүний нөөц хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч
Нарийн Батмөнхийн бичиг: Батбилэг	"Чингис Хаан" олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын хорио цээрийн албаны цөмийн болон цацрагийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.

\* 1439907 1309

3. Ёс зүйн дэд хороонд шаардлагатай санхүүжилтийг тухай бүр шийдвэрлэж, байгууллагын төсөвт тусгуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтыг газрын даргад даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын даргад үүрэг болгосугай.

ДАРГА



Р.ОТГОНЖАРГАЛ







ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМ  
**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ**  
**БУРГАСТАЙ ДАХЬ ГААЛИЙН ХОРООНЫ**  
**ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 1/04

Есөнбулаг

┌ Ёс зүйн дэд хороо байгуулах тухай ┐

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоол “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг тус тус үндэслэн Тушаах нь:

1. Байгууллагын ёс зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ёс зүйн дэд хорооны дарга:	Д.Жамбалсүрэн / Нягтлан бодогч, гаалийн улсын байцаагч /
Нарийн бичгийн дарга:	М. Арьяачойжил / Гаалийн улсын байцаагч/
Гишүүн:	Д.Даашинхүү / Гаалийн улсын ахлах байцаагч/

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг ёс зүйн дэд хороо / Д.Жамбалсүрэн /-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д. ЭРДЭНЭСҮХ

8217010043

## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2009 оны 10 дугаар сарын  
19-ний өдөр

Дугаар 534

Улаанбаатар хот

### ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Гаалийн тухай хуулийн 274.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2.Дүрмийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, хамтын ажиллагааны газар /Л.Дэлгэрбаяр/, Улаанбаатар хот, аймаг орон нутаг дахь гаалийн газар, хороо, дэргэдэх байгууллагын удирдлагад даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Улсын Гаалийн ерөнхий газрын даргын 2007 оны 671 дүгээр тушаалыг хүчингүй болсон тооцсон.

4. Энэ тушаалыг 2009 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Д.ЦЭВЭЭНЖАВ



## ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм” /цаашид “дүрэм” гэх/-ийн зорилго нь хууль дээдлэх, ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдлыг хангах, захирах, захирагдах, ард түмэндээ үйлчлэх, хүний эрх эрх чөлөөг хүндэтгэх, мэргэшсэн, тогтвортой байх төрийн албаны зарчмуудыг гаалийн улсын байцаагч үйл ажиллагаандаа удирдлага болгон, гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гаалийн байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, хяналт тавих, иргэд, байгууллагад төрийн үйлчилгээ үзүүлэх, албан үүргээ биелүүлэхдээ баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоох, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.3.Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ нь Гаалийн ариун шударга ёсны тухай Дэлхийн гаалийн байгууллагын Арушагийн тунхаглал, Гаалийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэ дүрмээр зохицуулагдана.

1.4.Гаалийн ерөнхий газар, түүний дэргэдэх байгууллага, Улаанбаатар хот, аймаг, орон нутаг дахь гаалийн газар, хороо /цаашид “гаалийн байгууллага” гэх/-ны удирдах албан тушаалтан /цаашид гаалийн байгууллагын удирдах албан тушаалтан” гэх/ нь ёс зүйн хэм хэмжээг чанд сахин, үлгэр дууриал болж манлайлан ажиллана.

1.5.Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1.“Гаалийн улсын байцаагчийн ёс зүй” гэж гаалийн улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ энэ дүрмийн 1.3 дахь заалтаар тогтоосон хэм хэмжээний нийлбэр цогцыг;

1.5.2.“Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн зөрчил” гэж гаалийн улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ энэ дүрмийн 1.3 дахь заалтаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл /эс үйлдэхүй/ -ийг.

### Хоёр. Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ

2.1.Ёс зүйн хэм хэмжээ нь гаалийн улсын байцаагч хууль тогтоомжоор хүлээсэн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх, гаалийн байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг, ухамсар, ёс суртахууныг төлөвшүүлэхэд чиглэнэ.

2.2.Гаалийн улсын байцаагч хууль тогтоомжийг дээдлэн өргөсөн тангарагтаа үнэнч байж, дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан ажиллана:

2.2.1.ажил, албан тушаалдаа хүндэтгэлтэй хандаж, гаалийн байгууллагын нэр хүндийг эрхэмлэж, олон нийтийн итгэлийг хүлээх;

2.2.2.төв, шударга ёсыг сахих, зохисгүй харьцаа, үйлдэл /эс үйлдэхүй/ гаргахгүй байх;

2.2.3.төрийн үйлчилгээ үзүүлэхдээ албаны нэр хүндийг дээдлэн хариуцлагатай хандаж, хүнд суртлаас ангид байх;

2.2.4.бусдын нөлөөнд үл автах, албан тушаалыг нь урвуулан ашиглахыг санаархсан аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх;

2.2.5.хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өртөхгүй байх, /харилцан хамаарал бүхий этгээдийн бараа, тээврийн хэрэгслийг шалгах, бүрдүүлэлт хийх гэх мэт/;

2.2.6.гаалийн байгууллагаас явуулж буй бодлого, үйл ажиллагаа гуйвуулан тайлбарлах, олон нийтэд буруу, ташаа мэдээлэх, эсхүл түүнийг өөрийн санал санаачилга мэтээр ярихыг цээрлэх;

2.2.7.үүрэгт ажил болон түр хугацаагаар албан тушаал орлон гүйцэтгэх, албан томилолтоор ажиллахдаа албаны мэдээ, мэдээллийг албан бусаар мэдээлэхгүй байх, /тараахгүй байх/;

2.2.8.үйлчлүүлэгч хэл амаар доромжлох, илэрхий басамжлах, дарамт, шахалт үзүүлэх, сүрдүүлэх, халдлага үйлдэгдэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаалийн улсын байцаагч нь /бие, биедээ/ хууль тогтоомжийн хүрээнд харилцан туслалцаа үзүүлэх, хамгаалах, таслан зогсоох арга хэмжээг авах;

2.2.9.үйлчлүүлэгийн нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх;

2.2.10.үйлчлүүлэгчийн зүй ёсны шаардлага, санал, хүсэлт, зөвлөмжийг хүлээн авч шаардлагатай бол хэрэгжүүлэх талаар идэвх санаачилгатай ажиллах;

2.2.11.ажил, арга хэмжээнд оролцохдоо товлосон цагийг баримтлах;

2.2.12.албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг нэн даруй Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх;

2.2.13.албан үүрэгтэй нь холбогдуулан гадаад, дотоодын зочин, төлөөлөгч, иргэн, байгууллагаас өгсөн /албан тушаалынх нь нэг сарын цалин хөлснөөс дээш төгрөгөөр үнэлэгдэх/ бэлгийг хүлээн авсан даруй харьяалах гаалийн байгууллагын удирдлагад мэдэгдэж, зохих журмын дагуу тогтоосон хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлэгт мэдүүлэх;

### **Гурав. Гаалийн улсын байцаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

3.1.Гаалийн улсын байцаагчийн үйл ажиллагаанд хууль тогтоомжоор хориглосноос гадна дараах зүйлсийг хориглоно:

3.1.1.бүрэн эрхэд нь хамаарахгүй асуудалд хөндлөнгөөс оролцох, эрх мэдлээ ашиглан бусдыг басамжлах, нэр төрийг гутаах, дарамт, шахалт үзүүлэх;

3.1.2.албан тушаалаа өөрийн болон гэр бүлийнхээ санхүүгийн болон бусад асуудлыг шийдвэрлэхэд ашиглах, нөлөөлөх;

3.1.3.үйлчлүүлэгчийг ялгаварлан гадуурхах, чирэгдүүлэх, хүнд суртал гаргах;



3.1.4.гаалийн хяналт хэрэгжүүлэхээс бусад зорилгоор хилийн боомт, гаалийн хяналтын бүс, татваргүй барааны дэлгүүрт нэвтрэх /зорчигчийн хувьд нэвтрэх үл хамаарна./;

3.1.5.ажлын байранд зохимжгүй маргаан /хэрүүл/ гаргах, зүй бусаар авирлах;

3.1.6.албан тушаалын болон мэргэжил, мэргэшлийн байдлыг ашиглаж хууль бусаар ашиг, хонжоо олох, бусдад давуу байдал олгох, үйлчлүүлэгчид хувийн чанартай хүсэлт /зээлээр бараа авах, мөнгө зээлэх, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нь хэрэглэх, бусдын мөнгөөр гадаадад зорчих, хямд үнээр бараа худалдан авах, үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэхийг хүсэх зэрэг/ шууд буюу шууд бус /үйл хөдлөлөөрөө илэрхийлэх, хоёрдмол утгатай үг, яриа хэрэглэх зэрэг/-аар гаргах;

3.1.7.байгууллагын эд хөрөнгө, тээврийн хэрэгслийг хувийн зорилгоор ашиглах;

3.1.8.үүргээ хэрэгжүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдээс шан харамж авах;

3.1.9.гаалийн улсын байцаагч олон нийтийн газар танхайрах, харилцан зодолдох;

3.1.10.гаалийн байгууллагын удирдах албан тушаалтан гаалийн улсын байцаагчийн хувийн эд хөрөнгийг албаны болон хувийн зорилгоор ашиглах, тийм шийдвэр гаргах.

### **Дөрөв. Дүрмийн биелэлтэд хяналт тавих**

4.1.Ёс зүйн хэм хэмжээг хэрхэн сахин биелүүлж байгаа нь гаалийн улсын байцаагчийн ажлыг дүгнэх, дээд шатны албан тушаалд томилон ажиллуулах, шагнаж урамшуулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх, гадаад, дотоодод томилолтоор ажилуулах, суралцуулах, сахилга, хариуцлага тооцоход харгалзах үзүүлэлт болно.

4.2.Гаалийн улсын байцаагчийн ёс зүйд дээд шатны болон удирдах албан тушаалтан, гаалийн байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйд Гаалийн ерөнхий газрын удирдлага болон дээд шатны албан тушаалтан тус тус хяналт тавина.

4.3.Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг хэрхэн сахин биелүүлж байгаад бусад гаалийн улсын байцаагч хяналт тавих үүрэг хүлээнэ.

4.4.Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг хэрхэн сахин биелүүлж байгааг шалгах, дүгнэх, хянан шийдвэрлэхдээ албан тушаал, гавьяа шагнал, ажилласан жил зэргийг үл харгалзах зарчмыг удирдлага болгоно.

### **Тав. Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх, хүлээлгэх хариуцлага**

5.1.Энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл /эс үйлдэхүй/-ийг харьяалах бүтцийн нэгжийн даргын шийдвэрээр гаалийн улсын байцаагчийн “хяналтын карт”-д тэмдэглэнэ. Шаардлагатай гэж үзвэл тухайн гаалийн байгууллагын удирдлага /дарга/-ын зөвлөлөөр уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно.

5.2.Гаалийн улсын байцаагч ёс зүйн дүрэм зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэхдээ нотлох баримт, бодитой мэдээ, мэдээлэлд үндэслэнэ.

5.3.Ёс зүйн зөрчлийг хянан шалгах явцад үйлдэл нь сахилгын, эсхүл захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээ авна.

5.4.Иргэд, байгууллагаас гаалийн улсын байцаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг харьяалах гаалийн байгууллагын удирдлага шалгаж ажлын 10 хоногийн дотор дүгнэлт гаргана.

5.5.Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу түүнийг шалгахтай холбоотой материалыг уг асуудлыг шийдвэрлэх хүрээнд зөвхөн албан хэрэгцээнд ашиглана.

5.6.Шаардлагатай гэж үзвэл гаалийн улсын байцаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх асуудлыг Гаалийн ерөнхий газрын Сахилгын хороо хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.7.Ёс зүйн ноцтой зөрчил гаргасан, эсхүл 1 жилийн дотор 2 болон түүнээс дээш удаа ёс зүйн хэм хэмжээг зөрчвөл зөрчлийн шинж, үр дагавар, хор уршиг зэргийг харгалзан гаалийн улсын байцаагчид сахилгын шийтгэл ногдуулна.